



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/314

Номгон


Нийгмийн эгэх хариуцлагыг сайжруулах  
"MASAM-2" төслийн хүрээнд Эрүүл мэндийн  
анхан шатны тусламж үйлчилгээний чанарыг  
сайжруулах 2023 оны үйл ажиллагааны  
төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/104 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "MASAM-2" төсөлтэй хамтран хэрэгжүүлэх Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг удирдлага, арга зүйгээр хангаж, зөвлөн туслахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т, Түр оршин суугчдын судалгааг гаргахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

842310791



Аймгийн Засаг даргын .....-ны ..... дугаар сарын .....-ны  
 өдрийн ..... дүгээр захирамжийн хавсралт

**“MASAM-2” ТӨСЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ  
 ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ  
 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн, төсөв	Хариуцагч байгууллага	
					Үндсэн	Хамтрагч
1	2	3	4	5	6	7
1	Өрхийн ЭМТ ба баг дээр байгаа хүн амын мэдээллийн баазыг тулгах, шинэчлэх	Мэдээлэл нь бүрэн шинэчлэгдсэн Өрхийн ЭМТ ба багийн эзлэх хувь	Тодорхойгүй	100	Баянхонгор сумын ЗДТГ	Өрхийн эрүүл мэндийн төв
2	Түр оршин суугчдын судалгаа гаргах	Судалгааг шинэчлэн гаргасан Өрхийн ЭМТ ба багийн тоо	Тодорхойгүй	4 10	Баянхонгор сумын ЗДТГ	Өрхийн эрүүл мэндийн төв
3	Судалгааны нэгтгэлийг аймаг, орон нутгийн удирдлагуудад танилцуулах	Шийдвэрийн хэрэгжилтийн хувь	0	100	Баянхонгор сумын ЗДТГазар, Өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
4	Баянхонгор сумын ЗДТГ, ЭМГ, Өрхийн эрүүл мэндийн төвийн хүн амын мэдээлэл бааз хариуцсан дарга, мэргэжилтнүүдийн олон талт уулзалт хийж, түр оршин суугчдад ЭМАШТУ-г хүргэх оновчтой арга замыг тодорхойлох (Түр оршин суугчдад нэг төвлөрсөн байгууллагаар үйлчлэх)	Шийдвэрийн хэрэгжилтийн хувь	0	100	Баянхонгор сумын ЗДТГазар, Өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
5	Өрхийн ЭМТ-өөр үйлчлүүлэгчдээс QR код-оор	Нийт судалгаанаас QR код ашиглан	0%	50%	Өрхийн ЭМТ-үүд	Эрүүл мэндийн газар

1	2	3	4	5	6	7
	дамжуулж авах сэтгэл ханамжийн судалгааны эзлэх хувийг нэмэгдүүлэх	өгсөн сэтгэл ханамжийн судалгааны хувь				
6	Open data 1313.mn хөгжүүлэлтийн ашиглалтыг сайжруулах, хүсэлт явуулах, өрх, сумын ЭМТ-ийн ажил дүгнэх үзүүлэлтэд оруулах	Open data 1313.mn дээр мэдээлэл оруулсан хувь	80	99	ЭМГ	Өрхийн эрүүл мэндийн төв
7	Өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлдэг үйлчилгээний нэр төрлийг иргэдэд сурталчлах, мэдүүлэх	Үйл ажиллагаанд хамрагдсан үйлчлэх хүрээний хүн амын эзлэх хувь	Тодорхойгүй	50	Өрхийн ЭМТ ЭМГ	Баянхонгор сумын ЗДТГ
8	Хөтөч сувилагчийг чадавжуулж, ажлын байрны чиг үүргийг тодорхой болгох	Бүрэн орон тоогоор ажиллуулсан хөтөчийн тоо	0	Өрхийн ЭМТ бүр 1	Өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
9	Хүний нөөцийг бүрэн орон тоогоор ажиллуулах	Стандарт хангагдсан хувь	0.5	100	Өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
10	“Эрүүл монгол” хөдөлгөөний хүрээнд багийн иргэдийн спорт заалны хуваарьтай өдөрт эрүүл мэндийн боловсрол олгох цагтай болгох, ЭМБО үйл ажиллагаа хэрэгжүүлэх	Харъяалагдах хүн амын эзлэх хувь	Тодорхойгүй	Нийт насанд хүрэгчдийн 40 хувьд хүргэх	Баянхонгор сумын ЗДТГазар	Эрүүл мэндийн газар
11	Хөндлөнгийн үнэлгээ хийлгэж хэвших	Үнэлгээний тоо	1	3	Өрхийн ЭМТ	Эрүүл мэндийн газар
12	Гурвалсан гэрээний хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх цаглабарыг мөрдөх	Хугацаандаа хийдсэн өрхийн ЭМТ-ийн үнэлгээний тоо	0	4	ЭМГ	Аймгийн ЗДТГ

зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж зөвлөгөө авч ажиллана.

### **Найм. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

8.1.Гадаад, дотоод орчин өөрчлөгдсөнөөс гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд хоёр тал бичгээр санал тавьж, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



8.2.Гэрээний өөрчлөлтийг тухай бүрд нь хийж, талууд гарын үсэг зурж гэрээний анхны эх хувьд хавсаргана. Гэрээний анхны болон өөрчилсөн эхүүдийн хувь тус бүрийг хадгална.

8.3.Гэрээнд тусгагдаагүй чиг үүрэг, ажил үйлчилгээг талууд харилцан зөвшилцөж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулсны үндсэн дээр нэмэлт гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх болно.

### **Ес. Гэрээний хариуцлага**

9.1. Аймгийн Засаг дарга түүний Тамгын газраас өгсөн үүрэг даалгавар, хариутай албан бичиг, мэдээ тайланг хугацаанд нь шаардлагын дагуу гаргаж ирүүлэх, биелүүлээгүй тохиолдолд Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

9.2.Сумын Засаг дарга гэрээний хавсралтад тусгагдсан үүргийг хангалттай биелүүлсэн тохиолдолд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд хариуцлага, урамшууллыг олгох эсэхийг шийдвэрлэнэ.

  
 БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ  
 ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

  
 БАЯН-ӨВӨӨ СУМЫН ЗАСАГ  
 ДАРГА  Ж.ХАТАНБААТАР

2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр